

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮР БОЛОН БҮР ХУРААН АВСАН, ЦАРЦААСАН ХӨРӨНГИЙГ ЭРХЛЭН УДИРДАХ ТУХАЙ

/Анхдагч хууль/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүх, прокурор, мөрдөгч хуульд заасны дагуу түр болон бүр хураан авсан хөрөнгийг эрхлэн удирдах (цаашид “хөрөнгө эрхлэн удирдах” гэх)-тай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн

удирдах тухай хууль тогтоомж

2.1.Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хөрөнгө” гэж бүх төрлийн эдийн болон эдийн бус хөрөнгө буюу бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эрх, бодит эсвэл биет бус, шилжих боломжтой эсвэл шилжих боломжгүй, үнэлэгдэх боломжтой эсвэл үнэлэгдэх боломжгүй үнэ өртөг бүхий ашиг, эсвэл эд зүйлс, орлого, эсвэл ямар нэгэн бараа болгон хувиргасан буюу холилдсон эд зүйлс, криптовалютыг;

3.1.2.“түр хураасан хөрөнгө” гэж Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд хураан авсан хөрөнгийг;

3.1.3.“бүр хураан авсан хөрөнгө” гэж Эрүүгийн хуульд заасны дагуу нийтийн албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгосон, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор авсан эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээний дагуу хураан авсан хөрөнгө болон Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хураан авч улсын орлого болгосон хөрөнгийг;

3.1.4.“хураан авсан хөрөнгө” гэж түр болон бүр хураан авсан хөрөнгийг;

3.1.5.“хөрөнгө эрхлэн удирдах” гэж хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу хураан авч хадгалах, хамгаалах, захиран зарцуулахыг.

4 дүгээр зүйл.Хөрөнгө эрхлэн удирдах үйл ажиллагааны зарчим

4.1.Хөрөнгө эрхлэн удирдах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хөрөнгийн чанар, үнэ цэнийг хамгаалах;

4.1.2.улсын орлого болгосон хөрөнгийг шударга аргаар худалдан борлуулах;

4.1.3.хөрөнгийг үр ашигтай, нийтийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн захиран зарцуулах;

4.1.4.хөрөнгийн элэгдэл, хорогдол, хадгалалтын эрсдэлээс сэргийлэх;

4.1.5.улсын орлого болгосон хөрөнгө, түүний бүртгэл, захиран зарцуулалтыг ил тод байлгах;

4.1.6.ашиглах боломжгүй хөрөнгийг устгах, эсхүл дахин боловсруулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ЭРХЛЭН УДИРДАХ

5 дугаар зүйл.Хөрөнгө эрхлэн удирдах зөвлөл

5.1.Бүр хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдлагыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Хөрөнгө эрхлэн удирдах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) хэрэгжүүлнэ.

5.2.Зөвлөл нь Монголбанк, бүх төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, холбогдох бусад байгууллагын төлөөлөлтэй байна.

5.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

5.4.Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.8.хураан авсан хөрөнгөтэй холбогдох бүртгэлийг хөтлөх, худалдан борлогдоогүй хөрөнгийн жагсаалт, үйл ажиллагааны тайланг улирал тутам гаргаж Зөвлөлд хүргүүлэх, олон нийтэд ил тод мэдээлэх;

6.2.9.хуульд заасан бусад.

6.3.Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хөрөнгө эрхлэн удирдахтай холбоотой шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

6.4.Хөрөнгө хамгаалах албаны бүтэц, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

7 дугаар зүйл.Түр хураан авсан хөрөнгийг эрхлэн удирдах

7.1.Түр хураан авсан, худалдан борлуулах шаардлагагүй хөрөнгийг шүүхийн шийдвэр гарах хүртэл энэ хуульд заасан Хөрөнгө хамгаалах алба хадгалж, хамгаална.

7.2.Түр хураагдсан хөрөнгийг бүртгэх бөгөөд бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

7.2.1.хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл;

7.2.2.хөрөнгө хүлээн авах үеийн байдал, түүний гэрэл зураг, дуу-дүрсний бичлэг;

7.2.3.хөрөнгийн зах зээлийн үнэ, үнэлгээ;

7.2.4.хөрөнгө хадгалагч этгээд, хөрөнгийн байршил;

7.2.5. хөрөнгийг итгэмжлэн хариуцаж байгаа этгээд;

7.2.6. хөрөнгийг худалдан борлуулсан бол түүний орлого;

7.2.7.бусад шаардлагатай мэдээлэл.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан бүртгэлийг дэлгэрэнгүй хөтлөх агуулга, хэлбэр, бүртгэл хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.4.Түр хураан авсан хөрөнгийг хадгалж, хамгаалахтай холбоотой энэ хуульд зааснаас бусад тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг адилтган хэрэглэнэ.

7.5.Хөрөнгө хамгаалах алба нь түр хураасан хөрөнгийг хөрөнгө хадгалахад шаардлагатай байр, агуулах, сав, тоног төхөөрөмж, нутаг дэвсгэр, зохих мэргэшсэн багаж хэрэгсэл, ажилтантай төрийн байгууллагад хөрөнгийг түр хариуцуулан хадгалуулж болно.

7.6.Үнэт металл, эрдэнийн чулуу, тэдгээрийг оролцуулан бүтээсэн үнэт эдлэл, түүх соёлын хосгүй болон бусад үнэт, дурсгалт зүйлийг Хөрөнгө хамгаалах алба нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үнэ бүхий эд зүйл хадгалах тусгай зориулалтын байранд түр хадгалуулна.

7.7.Хөрөнгө хамгаалах алба нь гадаад валют, төгрөгийг төрийн өмчит банкинд гэрээний үндсэн дээр арилжааны банкны дундаж хүүтэй тэнцэх хэмжээний хүүтэйгээр хадгална.

7.8.Түр хураасан хөрөнгө нь хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд чанар нь түргэн муудах болон хадгалахад өндөр зардалтай бөгөөд тухайн хөрөнгийг адил хөрөнгөөр орлуулах бүрэн боломжтой тохиолдолд Хөрөнгө хамгаалах алба нь тухайн хөрөнгийг худалдан борлуулж, борлуулснаас олсон мөнгөн хөрөнгийг энэ хуулийн 7.7-д заасны дагуу хадгална.

7.9.Түр хураан авсан хөрөнгийг 7.8-д заасны дагуу худалдан борлуулах тохиолдолд зах зээлийн үнээр дуудлага худалдааны доод үнийг тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдана.

7.10.Түр хураасан хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар борлуулж чадаагүй тохиолдолд зах зээлийн үнээр шууд гэрээгээр худалдаж болно.

7.11.Түр хураасан хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогыг шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд төрийн өмчит банкинд гэрээний үндсэн дээр арилжааны банкны дундаж хүүтэй тэнцэх хэмжээний хүүтэйгээр, хугацаагүйгээр хадгална.

7.12.Шүүхээс тухайн хөрөнгийг хураан авахгүйгээр шийдвэрлэсэн тохиолдолд хөрөнгө борлуулснаас олсон мөнгөн хөрөнгийг тухайн хугацааны хүүгийн хамт хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч этгээдэд буцаан олгоно.

7.13.Энэ хуулийн 7.12-т заасны дагуу мөнгөн хөрөнгө, хүүг Хөрөнгө хамгаалах алба шүүхийн шийдвэрийг үндэслэн өөрийн санаачилгаар, эсхүл хөрөнгө өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтээр буцаан олгоно.

7.14.Шүүхээс тухайн хөрөнгийг хураан авч улсын орлого болгохоор шийдвэрлэсэн тохиолдолд хөрөнгө борлуулснаас олсон мөнгөн хөрөнгийг тухайн хугацааны хүүгийн хамт улсын орлого болгож Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд төвлөрүүлнэ.

7.15.Шүүхийн шийдвэрээр хураан авсан тухайн хөрөнгөнөөс хохирол нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хөрөнгө борлуулснаас олсон мөнгөн хөрөнгө болон мөнгөн хөрөнгийг хадгалуулсан тухайн хугацааны хүүгийн орлогоос хохирлыг нөхөн төлнө. Хохирол нөхөн төлөөд илүү гарсан хөрөнгийг улс орлого болгож Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд төвлөрүүлнэ.

8 дугаар зүйл.Бүр хураан авсан хөрөнгийг эрхлэн удирдах

8.1.Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр бүр хураан авч, улсын орлого болгохоор шийдвэрлэсэн хөрөнгийг хураан авч худалдан борлуулах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу гүйцэтгэж,

худалдан борлуулснаас олсон орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд төвлөрүүлнэ.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасны дагуу борлогдоогүй болон Зөвлөлөөс захиран зарцуулах шийдвэр гаргах шаардлагатай хөрөнгийн жагсаалт, мэдээллийг Хөрөнгө хамгаалах алба нь улирал тутам гаргаж Зөвлөлд хүргүүлнэ.

8.3.Энэ хуулийн 8.1-д заасны дагуу борлогдоогүй хөрөнгийг энэ хуульд заасны дагуу захиран зарцуулах, түрээслэх асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

8.4.Хүн, мал амьтан, байгаль орчин, эрүүл ахуй, хорио цээр, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хөрөнгийг төрийн байгууллага, төрийн өмчит эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагад ашиглах, дахин боловсруулах боломжгүй бол Зөвлөлийн шийдвэрээр, холбогдох чиглэлийн мэргэжлийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын хяналт дор, холбогдох стандарт, журмын дагуу Хөрөнгө хамгаалах алба устгана.

8.5.Устгах ажиллагааг дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулан гүйцэтгэх бөгөөд устгах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8.6.Гадаад валют, төгрөгийг улсын орлого болгохоор шүүхээс шийдвэрлэсэн тохиолдолд мөнгөн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд төвлөрүүлнэ.

8.7.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан түүх, соёлын өв, дурсгалд хамаарах эд зүйлийг хураан авч улсын орлого болгосон бөгөөд худалдан борлогдоогүй бол тухайн түүх, соёлын өв, дурсгалд хамаарах эд зүйлийг Зөвлөлийн шийдвэрээр Соёлын өвийг хамгаалах газарт шилжүүлэх бөгөөд Соёлын өвийг хамгаалах газар тус хөрөнгийг бүртгэн хүлээн авна.

8.8.Орон сууцны бус зориулалттай үл хөдлөх хөрөнгө болон нэг тэрбум төгрөгөөс дээш үнэ бүхий үл хөдлөх эд хөрөнгийг хураан авч улсын орлого болгосон бол тухайн хөрөнгийн захиран зарцуулалтыг Зөвлөл шийдвэрлэнэ.

8.9.Шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг хураан авч улсын орлого болгосон бол тухайн хөрөнгийг Зөвлөлийн шийдвэрээр холбогдох эрдэм шинжилгээний төрийн өмчит байгууллагад шилжүүлэх ба хүлээн авсан байгууллага тухайн хөрөнгийг эрдэм, шинжилгээ судалгааны ажилд ашиглана.

8.10.Хураан авч улсын орлого болгосон хөрөнгө нь төрийн байгууллага, төрийн өмчит эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын хүсэлтийг үндэслэн Зөвлөлийн шийдвэрээр тухайн байгууллагын үйл ажиллагаанд зориулалтын дагуу ашиглуулахаар шилжүүлж болно.

8.11.Хураан авч улсын орлого болгосон хөрөнгө нь үнэт метал, үнэт чулуу(алт, мөнгө гэх мэт Монголбанк худалдан авах боломжтой үнэт метал, үнэт чулуу) бол Монголбанкинд тухайн үеийн ханшаар тушааж, үүнээс олсон орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд төвлөрүүлнэ.

8.12.Хураан авч улсын орлого болгосон хөрөнгө нь түрээслэгч, хөлслөгчтэй тохиолдолд хөрөнгийг худалдан борлуулалгүйгээр Зөвлөлийн шийдвэрээр үргэлжлүүлэн түрээсэлж, хөлсөлж болно.

8.13.Хөрөнгийг түрээслэх, хөлслөхөөр Зөвлөлөөс шийдвэрлэсэн бол хөрөнгийг түрээслэх, хөлслөх ажиллагааг Хөрөнгө хамгаалах алба хариуцан зохион байгуулах ба түрээсийн болон хөлсөлсний орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд төвлөрүүлнэ.

8.14.Бүр хураан авсан хөрөнгийг улсын орлого болгох зорилгоор шийдвэр гүйцэтгэлийн журмаар хураан авах, хадгалах, хамгаалах, худалдан борлуулахтай холбоотой энэ хуульд зааснаас бусад тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг адилтган хэрэглэнэ.

9 дүгээр зүйл.Царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах

9.1.Хуульд заасны дагуу царцаасан хөрөнгийн эрхлэн удирдлагыг холбогдох хуульд заасны дагуу эрхлэн удирдана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ЭРХЛЭН УДИРДАХ АЖИЛЛАГААНААС ОЛСОН ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ, ХУРААН АВСАН ХӨРӨНГИЙН ЭРХЛЭН УДИРДАХ АЖИЛЛАГААНААС ОЛСОН ОРЛОГЫН САН

10 дугаар зүйл.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сан

10.1.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сан /цаашид "сан" гэх/-гийн хөрөнгөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴.1-д заасан дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

10.1.1.авлигын мэдээлэгчийг урамшуулах үйл ажиллагааны санхүүжилтэд 10 хувийг;

10.1.2.хүн амын эрүүл мэнд, боловсролыг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэхэд 90 хувийг.

10.2.Сантай холбогдох бусад харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл.Авлигын мэдээлэгчийг урамшуулах

11.1.Авлигын мэдээлэгчийг урамшуулах үйл ажиллагаанд санхүүжилт олгох асуудлыг Авлигын эсрэг хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл.Хүн амын эрүүл мэнд, боловсролыг дэмжих зарим үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

12.1.Энэ хуулийн 10.1.2-т заасан дэмжлэгийг хүн амын эрүүл мэнд, боловсролын бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих үйл ажиллагааны хүрээнд эмнэлэг, цэцэрлэг, сургууль барихад зориулан олгоно.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан санхүүжилтийн зарцуулалтын тайланг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Ажлын албанд хүргүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

13 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

13.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

14 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

14.1.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/21⁴ дүгээр зүйл:

**“21⁴ дүгээр зүйл.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах
ажиллагаанаас олсон орлогын сан**

21⁴.1.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

21⁴.1.1.авлигын мэдээлэгчийг урамшуулах үйл ажиллагаанд 10 хувийг;

21⁴.1.2.хүн амын эрүүл мэнд, боловсролыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 90 хувийг.

21⁴.2.Авлигын мэдээлэгчийг урамшуулах үйл ажиллагаанд санхүүжилт олгох асуудлыг Авлигын эсрэг хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21⁴.3.Энэ хуулийн 21⁴.1.2-т заасан дэмжлэгийг хүн амын эрүүл мэнд, боловсролыг санхүүжилтээр дэмжих үйл ажиллагааны хүрээнд эмнэлэг, цэцэрлэг, сургууль барихад зориулан олгоно.

21⁴.4.Энэ хуулийн 21⁴.3-т заасан санхүүжилтийн зарцуулалтын тайланг эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тус сангийн Ажлын албанд тус бүр хүргүүлнэ.

21⁴.5.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Ажлын алба хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

21⁴.6.Сан нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд уг Удирдах зөвлөл нь Удирдах зөвлөлийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

21⁴.7.Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тоо нийт 9 байх ба Удирдах зөвлөлийн дарга, гишүүнээс бүрдэнэ. Гишүүдийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын болон олон нийтийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулсан байна.

21⁴.8.Удирдах зөвлөлийн дарга, гишүүн саналын тэнцүү эрхтэй байна.

21⁴.9.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авч улсын орлого болгосон болон Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу хураан авсан, нөхөн төлүүлсэн хөрөнгийг эрхлэн удирдсанаас олсон орлогыг Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд тухай бүр төвлөрүүлнэ.

21⁴.10.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу хөрөнгө төвлөрүүлэх бөгөөд хөрөнгө төвлөрүүлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

21⁴.11.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн хөрөнгийг энэ хуулийн 21⁴.1-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

21⁴.12.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн дүрэм, Удирдах зөвлөл, түүний Ажлын албаны бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журам болон уг сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалт:

“3.1.10. “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа” гэж Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн 4.1.15-д заасныг.”

2/18 дугаар зүйлийн 18.4.12 дахь заалт:

“18.4.12. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах.”

3/18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг:

“18.7. Авлигатай тэмцэх газар нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулахдаа Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, энэ хуульд заасан журмыг баримтална.”

4/24 дүгээр зүйлийн 24.1.11 дэх заалт:

“24.1.11. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасан мөрдөгчийн эрх, үүргийг эдэлж, хуульд заасан үндэслэл, журмын дагуу хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах.”

5/26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг:

“26.4. Прокурорын байгууллага нь Авлигатай тэмцэх газрын хууль бус хөрөнгө шалгах ажиллагаанд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт тавина.”

2 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “хууль бус хөрөнгө хураан авах, нөхөн төлүүлэх,” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах,” гэсний дараа “нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн

төлүүлэх зорилгоор хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах,” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “мөрдөн байцаах,” гэсний дараа “хууль бус хөрөнгө шалгах,” гэж, 18 дугаар зүйлийн 18.4.5 дахь заалтын “таслан зогсоох” гэсний дараа “нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх” гэж, тус зүйлийн 18.4.10 дахь заалтын “гүйцэтгэх ажил,” гэсний өмнө “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа,” гэж, 23 дугаар зүйлийн 32.1.7 дахь заалтын “гүйцэтгэх” гэсний өмнө “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа,” гэж, 24 дүгээр зүйлийн гарчиг, 24.1 дэх хэсгийн “гүйцэтгэх,” гэсний өмнө “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн дараах зүйл, Тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын Тайлбар:

“Тайлбар: Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэл, нотолгоотой тайлбарлаж чадаагүй тохиолдолд хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзнэ.

Тайлбар: “Илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэл, нотолгоотой тайлбарлаж чадаагүй” гэж тухайн хөрөнгө, орлогоо хууль ёсны болохыг үндэслэлтэй тайлбарлаж нотлох баримт гаргаж өгөөгүй, эсхүл нотлох баримтыг зааж өгөөгүй, эсхүл нотлох баримтыг зааж өгсөн хэдий ч тухайн үйл баримт нотлох баримтаар тогтоогдохгүй байхыг ойлгоно.”

2/9 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх

9.1.Иргэн, хуулийн этгээд авлигын талаарх өргөдөл, гомдлыг амаар, бичгээр Авлигатай тэмцэх газарт гаргаж болно.

9.2.Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

9.3.Иргэн, хуулийн этгээд авлигын талаарх мэдээллийг амаар, бичгээр Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагад гаргаж болох бөгөөд авлигын талаарх нотлох баримтыг хамт хүргүүлж болно.

9.4.Авлигын талаар мэдээлэл өгсөн этгээд(цаашид “авлигын мэдээлэгч” гэх)-ийн хувийн мэдээллийг нууцлах бөгөөд түүний зөвшөөрөлгүйгээр хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцуулах, авлигын мэдээлэгчийн хувийн мэдээллийг задруулах, бусдад дамжуулахыг хориглоно.

9.5.Авлигын мэдээлэгч, түүний гэр бүлийн гишүүн, үр хүүхэд, ойрын төрөл, садангийн хүний аюулгүй байдлыг хангах шаардлагатай тохиолдолд Гэрч,

хохилогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу тэдгээрийг хамгаалалтад авна.

9.6.Авлигын мэдээлэгчээс өгсөн тухайн мэдээлэл нь хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар нотлогдож, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд хураан авсан хууль бус хөрөнгийн болон эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээ, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураасан үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг тухайн авлигын мэдээлэгчид олгоно.

9.7.Авлигын талаарх нэг мэдээллийг хоёр буюу түүнээс дээш авлигын мэдээлэгч мэдээлсэн бол энэ хуулийн 9.6-д заасан урамшууллыг тухайн авлигын мэдээлэгч нарт тэнцүү хэмжээгээр хуваан олгоно.

9.8.Шүүхийн ерөнхий зөвлөл нь хууль бус хөрөнгө хураан авсан, нөхөн төлүүлсэн, эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээ авсан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гарснаас хойш 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Хөрөнгө хамгаалах албанд тухай бүр хүргүүлнэ.

9.9.Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллага энэ хуулийн 9.7-д заасан шүүхийн шийдвэрийг хүлээн авч, авлигын мэдээлэгчээс өгсөн мэдээлэл нь нотлогдож шийдвэрлэгдсэн байдлыг үндэслэн шүүхийн шийдвэрээр хураан авсан, нөхөн төлүүлсэн болон эд хөрөнгө хураах албадлагын арга хэмжээ, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураасан үнийн дүнгээс авлигын мэдээлэгчид олгох урамшууллын хэмжээг тооцож, хагас жил тутам Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Ажлын албанд холбогдох шийдвэр, мэдээлэл өгсөн баримтын хамт хүргүүлнэ.

9.10.Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын сангийн Удирдах зөвлөл нь Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллагаас ирүүлсэн авлигын мэдээлэгчид олгох урамшууллын тооцоог холбогдох шүүхийн шийдвэр, мэдээлэл өгсөн баримтын хамт хянаж, авлигын мэдээлэгчид урамшууллыг олгоно.”

4 дүгээр зүйл.Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “үндэслэлгүйгээр хөрөнгөжих” гэснийг “хууль бусаар хөрөнгөжих” гэж, 18 дугаар зүйлийн 18.4.11 дэх заалтын “энэ хуулийн 6.6, 7.1.7, 7.1.8-д заасан зөрчлийг хянан шалгаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх” гэснийг “энэ хуулийн 6.6, 7.1-д заасан зөрчлийг шалгаж, хуульд заасан эрх бүхий албан тушаалтан, байгууллагад шилжүүлэх, хүргүүлэх, холбогдох арга хэмжээ авах” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

1/3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт:

“3.1.7.“хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа” гэж Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн 4.1.15-д заасныг.”

2/10 дугаар зүйлийн 10.11.12 дахь заалт:

“10.11.12.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа явуулах.”

2 дугаар зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “хэрэг бүртгэх” гэсний өмнө “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын “хэрэг бүртгэлт,” гэсний өмнө “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа” гэж, 62 дугаар зүйлийн 62.7.1 дэх заалтын “мөрдөн байцаах” гэсний дараа “, хууль бус хөрөнгө шалгах” гэж, 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсгийн “хэрэг бүртгэх” гэсний өмнө “хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа, ” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ..дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт:

“4.1.5.“мэдээлэгч” гэж нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл өгсөн, өргөдөл, гомдол гаргасан хүнийг.”

2/21 дүгээр зүйлийн 21.2.5 дахь заалт:

“21.2.5.мэдээлэгчийг хамгаалах асуудлаар мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллагын хүсэлтээр мөрдөгч.”

2 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “хүний эрх хамгаалагч” гэсний дараа “, мэдээлэгч, түүний гэр бүлийн гишүүн, үр хүүхэд, төрөл, садангийн хүн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн “хамгаалагчийн” гэснийг “хамгаалагч, мэдээлэгчийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай бүлэг, хэсэг, заалт нэмсүгэй.

1/6 дугаар зүйлийн 6.2.7, 6.2.8 дахь заалт:

“6.2.7.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгө түр хураах тухай шүүгчийн захирамж;

6.2.8.Эрүүгийн хууль болон Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгийг хураан авч улсын орлого болгосон шүүхийн шийдвэр.”

2/20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг:

“20.5.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу түр хураан авсан хөрөнгийг биет байдлаар нь дуу-дүрсний бичлэгээр баримтжуулан, тэмдэглэл үйлдэж мөрдөгч, эсхүл прокурор, шүүхээс хүлээн авна.”

3/31 дүгээр зүйлийн 31.7 дахь хэсэг:

“31.7.Энэ хуулийн 120¹ дугаар зүйлд заасны дагуу ажиллагаа явуулж байгаа гүйцэтгэх баримт бичгийг буцаахыг хориглоно.”

4/АРВАН ГУРАВДУГААР¹ БҮЛЭГ:

“АРВАН ГУРАВДУГААР¹ БҮЛЭГ НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ ИРГЭНИЙ ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ХӨРӨНГИЙГ ТҮР ХУРААН АВСАН, ХУРААН АВЧ УЛСЫН ОРЛОГО БОЛГОСОН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА

122¹ дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгийг түр хураасан, хураан авч улсын орлого боулгосон шийдвэрийг биелүүлэх ажиллагаа

122¹.1.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу түр хураасан хөрөнгийг Түр болон бүр хураасан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хууль болон энэ бүлэгт заасан журмын дагуу хураан авч, хадгалж, хамгаалж, худалдан борлуулна.

122¹.2. Энэ хуулийн 122¹.1-д заасан ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хөрөнгө хамгаалах алба гүйцэтгэнэ.

122¹.3.Энэ хуулийн 20.5-д заасны дагуу хөрөнгийг хүлээн авахдаа эд зүйлсийн төрөл, шинж байдал, тоо, ширхэгийг тусган жагсаалт үйлдэж, хураан авна.

122¹.4.Хураан авсан хөдлөх хөрөнгийн шинж чанарыг харгалзан хадгалуулахаар зохих байгууллагад шилжүүлэх эсхүл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай гэрээ байгуулсан бусад этгээд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай зориулалтын байранд хадгалуулна.

122¹.5.Хураан авч улсын орлого болгосон үл хөдлөх хөрөнгийг хураан авахдаа өмчлөгч, эзэмшигчийг албадан гаргана.

122¹.6.Шийдвэр гүйцэтгэгч хураан авч улсын орлого болгосон хөрөнгийг 14 хоногийн дотор эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий үнэлгээчнээр үнэлүүлнэ. Шаардлагатай гэж үзвэл бүрэлдэхүүнтэй үнэлгээчин томилж болно.

122¹.7. Хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор худалдан борлуулах шийдвэр гаргаж, нийтэд мэдээлнэ.

122¹.8.Хөрөнгө худалдан борлуулахаар нийтэд мэдээлснээс хойш 15 хоногийн дотор үнэлгээчний тогтоосон үнээр дуудлага худалдааны доод үнийг тогтоож дуудлагаар худалдаж, дуудлага худалдааны ялагчид хөрөнгийг эрхийг шилжүүлэн хүлээлгэн өгнө.

122¹.9.Дуудлага худалдааны ялагч хөрөнгийн үнийг ажлын 3 өдрийн дотор төлөөгүй эсхүл хөрөнгө хүлээн авахаас татгалзсан тохиолдолд хөрөнгийг худалдан борлогдоогүйд тооцож, дэнчинг улсын орлого болгоно.

122¹.10.Хөрөнгө худалдан борлуулсан орлогоос шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг хасаж, орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгэр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд шилжүүлнэ.

122¹.11.Худалдан борлогдоогүй тохиолдолд Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

122¹.12.Энэ хуулийн 122¹.10, 122¹.11.-д заасны дагуу арга хэмжээ авснаар гүйцэтгэх баримт бичгийг биелүүлсэнд тооцно.

122¹.13.Нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг ердийн журмаар буюу энэ хуулийн Хоёрдугаар бүлэгт заасныг үндэслэн гүйцэтгэнэ.

122¹.14.Энэ бүлэгт заасан журмын дагуу явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гомдол гаргах эрхгүй.

122¹.15.Энэ хуулийн 122¹.14 дэх хэсэг нь энэ хуулийн 122¹.13-т заасны дагуу явуулсан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хамаарахгүй.

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “6.2.6” гэсний дараа “, 6.2.7” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 191 дүгээр зүйлийн 191.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“191.2.Хөрөнгө, орлогыг хураах шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрт заасан эд зүйл, хөрөнгийг хариу төлбөргүйгээр албадан хураан авах, улсын орлого болгох зорилгоор захиран зарцуулалтыг Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаар захиран зарцуулалтыг шийдвэрлүүлсний үндсэн дээр захиран зарцуулах, түрээслэх арга хэмжээг зохион байгуулах, эсхүл шүүхийн шийдвэрт заасны дагуу холбогдох төрийн байгууллагад шилжүүлэх, хураан авсан мөнгөн хөрөнгө болон худалдан борлуулж олсон орлогыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд төвлөрүүлэх арга хэмжээнээс бүрдэнэ.”

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсгийн “улсын төсөвт” гэснийг “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁴ дүгээр зүйлд заасан Хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогын санд” гэж, “Шаардлагатай тохиолдолд хураагдсан хөрөнгийг худалдан борлуулахгүйгээр улсын өмчид шилжүүлэхээр төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгнө.” гэснийг “Хуульд заасан шаардлагатай тохиолдолд Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаар захиран зарцуулалтыг шийдвэрлүүлсний үндсэн дээр захиран зарцуулах, түрээслэх арга хэмжээг зохион байгуулах, эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу холбогдох төрийн байгууллагад хүлээлгэн өгнө.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг:

“2.3.Төрийн аудиттай холбогдох харилцааг бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг баримтална.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.14, 4.1.15 дахь заалт

“4.1.14.“чанарын хяналт” гэж аудит болон бусад ажлыг тогтмол өндөр түвшинд гүйцэтгэх, гүйцэтгэсэн ажлынхаа чанартай холбоотой эрсдэлийг анхаарч, уг эрсдэлийг харгалзан үзэж хариу арга хэмжээ авах тогтолцоог;

4.1.15.“чанарын баталгаажуулалт” гэж чанарын хяналтын тогтолцоонд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зохистой хяналт байгаа эсэх, энэ нь үр нөлөөтэй ажиллаж байгаа эсэхийг хараат бусаар үнэлэх үйл ажиллагааг.”

3/6 дугаар зүйлийн 6.3.5, 6.3.6, 6.3.7 дахь заалт:

“6.3.5.төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, удирдлагад аудит хийх;

6.3.6.төр, орон нутаг хяналтын багц буюу түүнээс дээш хувийн хувьцааг нь эзэмшдэг компани, түүний охин компанид аудит хийхдээ төр, орон нутгаас хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлж байгаа байдлыг шалган дүгнэх;

6.3.7.улсаас зээл авсан, улсаас гаргасан татаасын тусламжтайгаар хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэр ашигласан этгээдийн тухайн зээл, хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийн ашиглалт, өрийн баталгаа гаргуулагчийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд аудит хийх.”

4/17¹ дүгээр зүйл:

“17¹ дүгээр зүйл.Төрийн аудитын чанарын удирдлага

17¹.1.Төрийн аудитын байгууллага энэ хуулийн 14.1-д заасан стандартад нийцсэн аудитын чанарыг хянаж, удирдах чанарын удирдлагын тогтолцоотой байна.

17¹.2.Төрийн аудитын байгууллага төрийн аудитын үйл ажиллагаанд тавих чанарын хяналтын бодлого, арга зүйг төрийн аудитын стандартад нийцүүлэн тодорхойлж, хэрэгжүүлнэ.

17¹.3.Төрийн аудитын байгууллага чанарын удирдлагын тогтолцоог хараат бусаар үнэлэх чанарын баталгаажуулалтын бодлого, арга зүйг төрийн аудитын стандартад нийцүүлэн тодорхойлж, хэрэгжүүлнэ.”

5/26 дугаар зүйлийн 26.2, 26.3 дахь хэсэг:

“26.2.Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторыг зургаан жилийн хугацаагаар нэг удаа томилно.

26.3.Төрийн аудитораар ажиллах иргэнийг туслах аудитораар нэг жилийн хугацаагаар түр томилно.”

6/28¹ дугаар зүйл:

“28¹ дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхий аудиторыг нэр дэвшүүлэх, томилох журам

28¹.1.Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө эсхүл Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын гурван өдрийн дотор Төсвийн байнгын хорооноос Монгол Улсын Ерөнхий аудиторт нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, 60 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна.

28¹.2.Энэ хуулийн 28.2-т заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

28¹.3.Төсвийн байнгын хороо энэ хуулийн 28¹.1-д заасан зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийг Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслээс хувь тэнцүүлсэн төлөөлөлтэйгөөр 10-15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

28¹.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг дараах журмаар зохион байгуулна:

28¹.4.1.энэ хуульд заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангасан нэр дэвшигчийг бүртгэж нийтэд мэдээлэх;

28¹.4.2.нэр дэвшигчийг тохиолдлын журмаар ажлын хэсгийн гишүүдэд тэнцвэртэй хуваарилж, илтгэгч гишүүнийг томилох;

28¹.4.3.илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийн баримт бичиг, олон нийтээс ирүүлсэн саналыг судлах, нэр дэвшигчтэй болон бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр мэдээллийг бүрдүүлж, тухайн нэр дэвшигч мэдлэг, ур

чадвар, ёс зүйн хувьд Монгол Улсын Ерөнхий аудитораар ажиллах боломжтой эсэх талаар дэлгэрэнгүй тайлан бичих;

28¹.4.4.ажлын хэсгийн гишүүд илтгэгч гишүүний тайлан болон холбогдох бусад баримт, мэдээлэлд үндэслэн нууцаар санал хурааж, нийт гишүүний дийлэнх олонхын санал авсан хүнийг нэр дэвшүүлж, Төсвийн байнгын хороонд гурван өдрийн дотор хүргүүлэх.

28¹.5.Төсвийн байнгын хороо энэ хуулийн 28¹.4.4.-т заасны дагуу ирүүлсэн тайланг хүлээн авснаас хойш дараах ажиллагааг хийнэ:

28¹.5.1.хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад мэдээллийг агуулсан тайланг ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах;

28¹.5.2.нэр дэвшигчийн сонсголыг Нийтийн сонсголын тухай хуулийн 18.7-д заасан журмын дагуу зохион байгуулах.

28¹.6.Төсвийн байнгын хороо нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулснаас хойш 7 хоногийн дотор нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилох эсэх асуудлаар Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

28¹.7.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхий аудитораар томилохоос татгалзсан бол ажлын хэсгийн нийт гишүүний олонхын санал авсан нэр дэвшигчдээс дараагийн хамгийн олон санал авсан хүнийг Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ. Хэрэв уг нэр дэвшигчийг Улсын Их Хурал томилохоос татгалзсан тохиолдолд сонгон шалгаруулалтыг дахин явуулна.

28¹.8.Энэ хуулийн 28¹.4.4, 28¹.7-д заасны дагуу явуулсан ажлын хэсгийн санал хураалтаар нэр дэвшигчийн авсан саналын тоо тэнцсэн бол тэнцүү санал авсан нэр дэвшигчдээр дахин санал хураалт явуулж нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.”

2 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “төрөлжсөн аудитын газар” гэсний дараа “, аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрыг хэд хэдэн аймгийн дунд тойргийн журмаар” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “иргэнийг ажиллуулна” гэсний дараа “төрийн аудитын байгууллагын албан хаагчийг нээлттэйгээр сонгон шалгаруулж томилно” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт:

“4.1.4 “шалгагдагч этгээд” гэж төсвийн байгууллага, Монголбанк, эрдэнэсийн сан, тусгай сан, орон нутгийн сан, төрийн болон орон нутгийн өмчит

хуулийн этгээд, төр болон орон нутаг хяналтын багц буюу түүнээс дээш хувийн хувьцааг нь эзэмшдэг компани, түүний охин компани, төрийн чиг үүргийг хууль, нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд, улсаас зээл авсан, улсын гаргасан татаасын тусламжтайгаар хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэр ашигласан, улсаас өрийн баталгааг нь гаргасан этгээд болон хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээдийг;

2/11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг:

“11.1.Монгол Улсын Ерөнхий аудитор дараагийн санхүүгийн жилд гүйцэтгэх аудитын сэдэв, цаглабарыг баталж, Улсын Их Хуралд хүргүүлнэ.

11.2.Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдэв, аудитын төлөвлөгөөг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг холбогдох этгээдээс энэ хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу гаргуулан авч болно. Холбогдох этгээд Монгол Улсын Ерөнхий аудитораас шаардсан мэдээлэл, баримт бичгийг тогтоосон хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.”

3/21 дүгээр зүйл:

“21 дүгээр зүйл.Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох

21.1.Төрийн аудитын байгууллага аудитын явцад залруулах боломжгүй улс, орон нутгийн төсөв, нийтийн өмчид хохирол учруулсан шалгагдагч этгээдийн хууль бус үйлдэлд төлбөрийн акт тогтооно.

21.2.Хохирлын хэмжээг улс, орон нутгийн төсөв, нийтийн өмчид учирсан бодит хохирлоор тодорхойлох бөгөөд үүнд олох байсан орлогыг тооцохгүй. Учирсан хохирлын хэмжээг буруутай этгээд нэг бүрээр тодорхойлно.

21.3.Төрийн аудитын байгууллага дараах үндэслэлээр шалгагдагч этгээдэд хугацаатай албан шаардлага өгнө:

21.3.1.зөрчил дутагдлыг аудитын явцад залруулах боломжгүй бөгөөд нэн даруй зогсоох шаардлагатай улс, орон нутгийн төсөв, нийтийн өмчид хохирол учирч болзошгүй эсхүл учирсан хохирол цаашид нэмэгдэх бодит нөхцөл байдал тогтоогдсон;

21.3.2.өмнөх аудитын зөвлөмжийн мөрөөр холбогдох үйл ажиллагаа, арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй;

21.3.3.энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэлээр.

21.4.Төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөх нөхцөл байдал нь нотлох баримтаар бүрэн дүүрэн тогтоогдсон байна.

21.5.Шалгагдагч этгээдийн үйл ажиллагаа гэмт хэргийн шинжтэй тохиолдолд төлбөрийн акт тогтоох, албан шаардлага үйлдэхгүйгээр аудитыг нэн даруй зогсоож энэ тухай Ерөнхий аудиторт мэдэгдэж, холбогдох материалыг

прокурорт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шалгуулахаар прокурорын багууллагад шилжүүлнэ.

21.6.Прокурорын байгууллага нь энэ хуулийн 21.5-д заасны дагуу шилжүүлсэн материалын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор Ерөнхий аудиторт хүргүүлж байна.

21.7.Энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудитораас шилжүүлсэн асуудлаар прокурор хэрэг бүртгэлийн хаах, прокурор, шүүхээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргасан тохиолдолд төрийн аудитын байгууллага энэ зүйлд заасан үндэслэлээр шалгадагч этгээдэд төлбөрийн акт тогтоож болно.

21.8.Энэ хуулийн 35.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудитораас шилжүүлсэн асуудалд гэм буруугүй гэж шүүхээс тогтоогдсон этгээдэд энэ хуулийн 21.8 дахь хэсэг хамаарахгүй.”

4/23 дугаар зүйл:

“23 дугаар зүйл.Акт, албан шаардлагын биелэлтийг хангах

23.1.Төрийн аудитын байгууллагын хүчин төгөлдөр болсон албан шаардлагыг энэ хуулийн 42.3, Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.

23.2.Хүчин төгөлдөр болсон төлбөрийн актыг дараах журмаар гүйцэтгэнэ:

23.2.1.буруутай этгээд зөвшөөрсөн тохиолдолд түүний үндсэн цалингийн 20 хувиас хэтрэхгүй хэмжээгээр сар бүр суутган тооцож хохирлыг барагдуулна. Энэ тохиолдолд тухайн байгууллагын нягтлан бодогч төрийн аудитын байгууллагын шийдвэрийг үндэслэн төлбөрийг сар бүр хураан авч төсөвт төвлөрүүлэх;

23.2.2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлд заасны дагуу шүүхийн гүйцэтгэх хуудсыг үндэслэн албадан гүйцэтгүүлэх.”

5/28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг:

“28.1.Монгол Улсын Ерөнхий аудиторыг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр нэр дэвшигчийн сонсгол хийж Улсын Их Хурал есөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.”

4 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 11.2.1-д зааснаас бусад” гэснийг “Монгол Улсын Ерөнхий аудитор” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга,” гэснийг “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын Тайлбар, 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“45.10.Энэ хуулийн 45.8-д заасан мэдээллийг агуулсан тэмдэглэлийг үйлдээгүй, эсхүл үйлдсэн тэмдэглэлийг битүүмжлээгүй, эсхүл тус хэсэгт заасан хугацааг 3 болон түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.1.17 дахь заалт нэмсүгэй:

“41.1.17. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах ажиллагааны явцад иргэний нэхэмжлэгчээс нийтийн албан тушаалтанд холбогдуулан гаргасан нэхэмжлэл.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Прокурорын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/11¹ дүгээр зүйл:

“11¹ дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт

11¹.1.Прокурор нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө шалгах ажиллагаанд дараах хяналт тавина:

11¹.1.1.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийн талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;

11¹.1.2.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

11¹.1.3.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө шалгах ажиллагааны явцад хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх;

11¹.1.4.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө шалгах ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангаж байгаа эсэх;

11¹.1.5.хөрөнгө шалгах тодорхой төрлийн ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх.”

2/12¹ дүгээр зүйл:

“12¹ дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх

12¹.1.Прокурор нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө шалгах ажиллагаанд хяналт тавихдаа Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12¹.1.1.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийн талаархи гомдол, мэдээллийг бүртгэх, хууль бус хөрөнгө шалгах ажиллагаанд дугаар олгох;

12¹.1.2.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах, түүнд хяналт тавих харьяаллыг тогтоох;

12¹.1.3.оролцогчийн гаргасан гомдол, бусад үндэслэлээр нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа, хэргийн материалыг хянах;

12¹.1.4.мөрдөгчийн үндэслэлгүй авсан албадлагыг хүчингүй болгох;

12¹.1.5.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаатай холбоотой гомдол, хүсэлтийг шийдвэрлэх;

12¹.1.6.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг шалгах;

12¹.1.7.хуульд заасан бусад.

3/13¹ дүгээр зүйл:

“13¹ дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын арга хэлбэр

13¹.1.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаанд тавих хяналтыг дараах арга, хэлбэрээр хэрэгжүүлнэ:

13¹.1.1.хяналтын ажлын бүртгэл хөтлөх;

13¹.1.2.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулах мөрдөгчийн судалгааг гаргуулан авч, хяналтад хамруулах;

13¹.1.3.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа явуулсан байдал, хэргийн материалтай танилцах, хянах;

13¹.1.4.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаанд шалгалт хийх, биечлэн оролцох.

4/17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт:

“17.1.4.нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг шүүхээр хянан шийдвэрлэх.”

5/18¹ дүгээр зүйл:

“18¹ дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох

18¹.1.Прокурор төр, нийтийн ашиг ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасан үндэслэл, журмын дагуу нийтийн албан тушаалтны хууль бус

хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг шүүхэд гаргаж, хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

18¹.2.Прокурор шүүх хуралдаанд бусад этгээдийг оролцуулах, гэрчээс мэдүүлэг авах, бусад нотлох баримтыг шинжлэн судлах талаар шүүхэд хүсэлт, шүүх хуралдааны дарааллын талаар санал гаргана.

18¹.3.Прокурор шүүх хуралдаанд оролцохдоо өөрийн гаргасан нэхэмжлэл, хүсэлт, тэдгээрийн хууль зүйн үндэслэлийн талаар тайлбар гаргана.”

2 дугаар зүйл.Прокурорын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1.9 дэх заалтын “зөрчил шалган” гэсний өмнө “нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө шалгах ажиллагаа, “ гэж, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “зөрчлийн” гэсний дараа “, нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө шалгах ажиллагааны” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“20 дугаар зүйл.Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах

20.1.Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасны дагуу, эсхүл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хуульд заасны дагуу, эсхүл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно.

20.2.Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх, хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй.

20.3.Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

20.4.Прокурор хуульд заасны дагуу болон өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцоно.”

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭДИЙН ЗАСГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.3 дахь хэсэг нэмсүгэй:

“2.3.Энэ хууль нийтийн албан тушаалтны хууль бусаар олсон хөрөнгө, орлогод хамаарахгүй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.17. Авлигатай тэмцэх газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, төрийн захиргааны төв байгууллага, холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн, нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ ИРГЭНИЙ
ЖУРМААР НЭХЭМЖЛЭХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тус хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэл хугацаанд буцаан хэрэглэнэ.

2 дугаар зүйл. Улс төрд нөлөө бүхий этгээдийг төрийн өндөр нийтийн албан тушаалд ажиллаж байх хугацаанд түүнд болон түүний хамаарал бүхий этгээдэд бий болсон хөрөнгийг шалгах ажиллагаанд заавал хамруулж 2026 оны 2 дугаар сараас шалгах ажиллагааг эхлүүлнэ.

Тайлбар: "Улс төрд нөлөө бүхий этгээд" гэж 2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, орлогч прокурор, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхий аудитор, Авлигатай тэмцэх газрын дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Ёс зүйн хорооны дарга, гишүүн, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга, Авлигатай тэмцэх газрын дэд дарга, дэд сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын тэргүүн дэд, дэд дарга, Монгол банкны тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Үндэсний статистикийн хорооны дэд дарга, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын албан тушаал хашиж байсан, хашиж байгаа хүнийг ойлгоно.

3 дугаар зүйл. Авлигын өндөр эрсдэл бүхий албан тушаалд энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд ажиллаж байх үед тухайн нийтийн албан тушаалтан болон түүний хамаарал бүхий этгээдэд бий болсон хөрөнгийг шалгах ажиллагаанд заавал хамруулж 2026 оны 6 дугаар сараас шалгах ажиллагааг эхлүүлнэ.

Тайлбар: "Авлигын эрсдэл өндөр албан тушаал"-д зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан, төрийн захиргааны төв байгууллагын газар, хэлтсийн дарга, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгч, төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал, олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаал хамаарна.

4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам 2025 онд багтаан авах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг 2026 оноос эхлэн жил бүрийн төсөвт тусган Монгол Улсын Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.9 дэх заалт нэмсүгэй:

“9.1.9. Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллага нь нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/74 дүгээр зүйлийн 74.4 дэх хэсэг:

“74.4.Нийтийн эрх ашигт гэм хор учруулснаас үүсэх үүрэг, гэм хор арилгахтай холбоотой шаардлага гаргахад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.”

2/497² дугаар зүйл:

**“497² дугаар зүйл.Хууль бусаар хөрөнгөжсөний улмаас
хариуцлага хүлээх үндэслэл**

497².1.Хууль бусаар, үндэслэлгүйгээр, эсхүл бусдыг хохироож хөрөнгө, ашиг олсон бол тухайн хөрөнгө, ашгийг буцаан төлөх, гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

497².2.Авлигын улмаас хөрөнгө олж авсан, бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн эрх ашигт гэм хор учруулсан гэж үзэх бөгөөд гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай ДОЛДУГААР² БҮЛЭГ нэмсүгэй:

**“ДОЛДУГААР² БҮЛЭГ.НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ
ХУУЛЬ БУС ХӨРӨНГИЙГ ХУРААН АВАХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ
ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

**75¹² дугаар зүйл.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө
хураан авах, нөхөн төлүүлэх хэрэг
хянан шийдвэрлэх**

75¹².1.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу гаргасан нэхэмжлэлтэй хэргийг энэ бүлэгт заасан журмаар хянан шийдвэрлэнэ.

75¹².2.Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлтэй хэргийг хянан шийдвэрлэхэд энэ бүлэг болон Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

75¹².3.Шүүх нэхэмжлэлийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуульд заасны дагуу явуулсан хөрөнгө шалгах ажиллагаагаар шалгагдсан нотлох баримтын хүрээнд шийдвэрлэнэ.

75¹².4.Хөрөнгө шалгах ажиллагаанд шалгагдаагүй нотлох баримтыг хэргийн оролцогч шүүхэд гаргасан тохиолдолд шүүх түүнийг үнэлэхгүй. Харин шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

75¹².5.Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх явцад хариуцагч шинээр нотлох баримт гаргаж өгсөн тохиолдолд уг баримтыг шүүх хэрэгт ач холбогдолтой гэж үзвэл хөрөнгө шалгах ажиллагаанд тус нотлох баримтыг шалгуулахаар шилжүүлнэ. Энэ тохиолдолд тухайн баримт шалгагдаж дуусах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлнэ.

75¹².6.Энэ хуулийн 75¹².5-д заасан нотлох баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны саад учруулах, удаашруулах зорилгоор гаргасан гэж үзвэл хөрөнгө шалгах ажиллагаанд шилжүүлэхгүй байж болно.

75¹².7.Энэ бүлэгт заасан нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлнө.

75¹².8.Шүүх нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 30 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

75¹².9.Энэ хуулийн 75¹².8-д заасан хугацааг шаардлагатай гэж үзвэл нэг удаа 7 хүртэл хоногоор сунгаж болно.

75¹².10.Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ хариуцагч нас барсан, оргон зайлсан, сураггүй алга болсон эсэхээс үл хамааран хэргийг хянан шийдвэрлэнэ.

75¹².11.Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авах боломжгүй, эсхүл хүлээн авахаас татгалзсан тохиолдолд энэ талаар тэмдэглэл үйлдэн хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлүүлнэ.

75¹².12.Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

75¹².13.Шүүх энэ хуулийн 77.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол хариуцагч иргэний болон хуулийн этгээдийн бүртгэлийн дугаарыг, эсхүл регистрийн дугаарыг мэдээлсэн нэхэмжлэлийн тухайд албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа хийнэ.

75¹².14.Энэ хуулийн 75¹².13-т заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагаас тодруулж ирүүлсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол иргэн, хуулийн этгээдтэй төрийн байгууллагаас харилцах төрийн мэдээллийн нэгдсэн системийн иргэний, эсхүл хуулийн этгээдийн хувьд түүнийг итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээдийн бүртгэлийн дугаар бүхий үндэсний цахим шуудангийн хаягаар, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээнэ.

75¹².15.Энэ хуулийн 75⁴ дүгээр зүйлд заасны дагуу хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг хэргийн оролцогчийн эрх, үүргийн тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, эрх, үүргийн тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 75⁴.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

75¹².16.Энэ хуулийн 75¹².14-т заасан цахим шуудангийн хаягаас гадна хариуцагчийн албаны болон хувийн цахим шуудангийн хаягийн мэдээллийг нэхэмжлэлд тусгасан бол эдгээр хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг давхар илгээнэ.

75¹².17.Энэ хуулийн 75¹².14-т заасны дагуу цахим шуудангийн хаягаар мэдэгдэх хуудсыг илгээснээс хойш 7 хоног өнгөрсөн бол мэдэгдэх хуудсыг хүлээн авсанд тооцно.

75¹².18.Хууль бус хөрөнгө шалгах ажиллагааны нөхцөл байдлыг харгалзан энэ хуулийн 25.1.3-т заасан эрхийг зөвхөн шүүх хуралдаанаас өмнө хүсэлт гаргах замаар эдэлнэ.”

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “шийдвэрлэх” гэсний дараа “, хууль бус хөрөнгө хураан авах, нөхөн төлүүлэх, буцаах талаар шүүхээс хянан шийдвэрлэх” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “өөрийн санаачилгаар” гэсний дараа “, эсхүл хуульд заасны дагуу” гэж, 184 дүгээр зүйлийн 184.1 дэх хэсгийн “улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг” гэсний өмнө “төрийн аудитын байгууллагын болон” гэж, мөн хэсгийн “улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт” гэсний өмнө “төрийн аудитын байгууллагын болон” гэж, мөн зүйлийн 184.3 дахь хэсгийн “улсын байцаагчийн” гэсний өмнө “төрийн аудитын байгууллагын болон” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/1.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг:

“11.Энэ хуулийн 22.1, 22.4, 22.10-т заасан гэмт хэрэг болон мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш хорин жил байна.”

2/9.2 дугаар зүйлийн 3, 4, 5 дахь хэсэг:

“3.Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж энэ зүйлийн 2.1, 2.2 дахь хэсэгт заасан албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

4.Энэ хуулийн 2.3-т заасан албадлагын арга хэмжээг дараах байдлаар оногдуулсан ял дээр нэмж хэрэглэнэ:

4.1.гэмт хэрэг үйлдэж хөрөнгө, орлого олсон бол тухайн хөрөнгө, орлогыг заавал хураан авах;

4.2.бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдээс албадан гаргуулах.

5.Энэ зүйлийн 4.1, 4.2-т заасан албадлагын арга хэмжээг гэмт хэргийн нөхцөл байдлаас хамааруулан хамтад нь хэрэглэж болно.”

3/17.13 дугаар зүйл:

“17.13 дугаар зүйл. Бусдын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг авах, хадгалах, шилжүүлэх, борлуулах

1.Бусдын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, шилжүүлсэн, борлуулсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Тайлбар-Энэ зүйлд заасан "гэмт хэрэг" гэдэгт энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн 18, 20, 22, 24, 25, 26, 29 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг, эсхүл гадаад улсад үйлдэгдсэн бөгөөд гадаад улсын хуулиар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргээс бусад гэмт хэрэг хамаарна."

4/22.14, 22.15 дугаар зүйл:

"22.14 дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах

1.Нийтийн албан тушаалтан хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд ажиллах эрхийг хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

22.15 дугаар зүйл.Шүүгч нөлөөллийн мэдүүлэг хөтлөхгүй байх

1.Шүүгч хуульд заасны дагуу нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй, эсхүл бүрэн бус, худал хөтөлсөн бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 6.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "зохион байгуулалттай гэмт хэрэг," гэсний дараа "эсхүл авлигын гэмт хэрэг," гэж, мөн хэсгийн "хамтран ажиллах этгээдийг" гэсний дараа "энэ хуульд заасан нөхцөл, болзлыг хангасан тохиолдолд" гэж, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "шалгах ажиллагааны үед" гэсний өмнө "болон хөрөнгө" гэж, 21.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "ятгасан" гэсний дараа "эсхүл бусад байдлаар нөлөөлөхийг оролдсон, нөлөөлсөн" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

"9.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан, **яллагдагч, шүүгдэгч нас барсан, өршөөлд хамрагдсан, яллагдагч, шүүгдэгч оргон зайлсан эсэхээс** үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно."

2/7.2 дугаар зүйл:

“7.2 дугаар зүйл.Албадлагын арга хэмжээний төрөл

1.Албадлагын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:

- 1.1.үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
- 1.2.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
- 1.3.хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

2.Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж энэ зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэгт заасан албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

3.Энэ зүйлийн 1.3-т заасан албадлагын арга хэмжээг дараах байдлаар оногдуулсан ял дээр нэмж хэрэглэнэ:

3.1.гэмт хэрэг үйлдэж хөрөнгө, орлого олсон бол тухайн хөрөнгө, орлогыг заавал хураан авах;

3.2.бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүнээс албадан гаргуулах.

4.Энэ зүйлийн 3.1, 3.2-т заасан арга хэмжээг гэмт хэргийн нөхцөл байдлаас хамааруулан хамтад нь хэрэглэж болно.”

3/7.5 дугаар зүйл:

“7.5 дугаар зүйл.Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

1.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.

2.“Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгсэл, эд хөрөнгийг ойлгох бөгөөд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг заавал хураана.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах боломжгүй бол гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хөрөнгө, орлогоос албадан гаргуулж нөхөн төлүүлнэ.

4.Гэмт хэрэг үйлдсэн этгээд хэн болох нь тогтоогдоогүй боловч гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдэг нь тогтоогдсон бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг заавал хураана.

5.Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэх, эсхүл улсын орлого болгож Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу зарцуулна.

6.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирол, хор уршгаас илүү гарсан тохиолдолд илүү хөрөнгө, орлогыг улсын төсөвт шилжүүлнэ.

7.Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу, эсхүл гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэхэд зарцуулна.

8.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг нөхөн төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, тухайн хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлэх, эсхүл Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуульд заасны дагуу зарцуулна.”

4/9.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Хуулийн этгээдэд хэрэглэх албадлагын арга хэмжээ нь дараах төрөлтэй байна:

- 2.1.эрх хасах албадлагын арга хэмжээ;
- 2.2.татан буулгах албадлагын арга хэмжээ;
- 2.3.хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.”

5/18.6 дугаар зүйл:

“18.6 дугаар зүйл.Мөнгө угаах

1.Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн 18, 20, 22, 24, 25, 26, 29 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг, эсхүл гадаад улсад үйлдэгдсэн бөгөөд гадаад улсын хуулиар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо ашигласан, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогынхоо эх үүсвэр, шинж чанар, байршил, захиран зарцуулах арга, өмчлөгч, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг өөрчилсөн, шилжүүлсэн, нуун далдалсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг

хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Бусдын үйлдсэн буюу энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жилээс дээш хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн 18, 20, 22, 24, 25, 26, 29 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг, эсхүл гадаад улсад үйлдэгдсэн бөгөөд гадаад улсын хуулиар хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эд хөрөнгийн эрх, өмчлөгч, эзэмшигчийг нуун далдалсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болохыг мэдсээр байж;

3.2.виртуал хөрөнгө ашиглаж;

3.3.хуулийн этгээдийг халхавчаар ашиглаж;

3.4.үндэстэн дамнаж;

3.5.байнга тогтвортой үйлдэж;

3.6.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

-Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 3.4-д заасан “үндэстэн дамнаж” гэдэгт дараах тохиолдлыг ойлгоно:

- энэ гэмт хэргийг улсын хил дамнуулан үйлдсэн бол;

- энэ гэмт хэргийг нэг улсад үйлдсэн боловч тухайн гэмт хэрэгт бэлтгэх, төлөвлөх, удирдан зохион байгуулах, хянах үйлдлийг өөр улсад хийсэн бол;

-энэ гэмт хэргийг нэг улсад үйлдсэн боловч тухайн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон зохион байгуулалттай гэмт бүлэг 2 буюу түүнээс дээш улсад гэмт хэргийн шинжтэй ажиллагаанд оролцдог бол;

-гэмт хэргийг нэг улсад үйлдсэн боловч бодит үр дагавар нь өөр улсад илэрсэн бол.”

6/22.1 дүгээр зүйл:

“22.1 дүгээр зүйл.Албан тушаалын эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах

1.Нийтийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан үйлдсэн, эсхүл энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд ажиллах эрхийг таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хасаж таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ хуульд заасан “нийтийн албан тушаалтан” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.4-т заасан албан тушаалтан, байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн, эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг ойлгоно.

-Энэ хуульд заасан “албан тушаалын эрх мэдэл” гэдэгт албаны бүрэн эрх, албан үүрэг, албаны эрх, үүрэг, албаны чиг үүрэг хамаарна.

-Энэ хуульд заасан “албан тушаалын байдал” гэдэгт албаны эрх нөлөө хамаарна.

-Энэ хуульд заасан “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж Авлигын эсрэг хуулийн 3.1.3-т заасныг ойлгоно.

-Энэ хуульд заасан “давуу байдал” гэж Авлигын эсрэг хуулийн 3.1.4-т заасныг ойлгоно.

-Энэ бүлэгт заасан “нийтийн албанд ажиллах эрхийг хасах” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1-д заасан албан тушаалд сонгогдох, томилогдох, ажиллах эрх хасахыг ойлгоно.”

7/22.4 дүгээр зүйл:

“22.4 дүгээр зүйл.Нийтийн албан тушаалтан хахууль авах

1.Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан, эсхүл бусад этгээд болон төлөөний хүнд хахуулийг өгүүлсэн, өгүүлэхээр тохиролцсон, өгөхийг шаардсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдсэн, эсхүл их хэмжээний хахууль авсан, эсхүл улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан үйлдсэн бол нийтийн албанд ажиллах эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний хахууль авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “онц их хэмжээ” гэдэгт нэг сая нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “бусад этгээд” гэдэгт хахуулийг өгүүлэхээр нийтийн албан тушаалтнаас санал болгосон, зааж өгсөн, тухайн гэмт хэрэгт хамтран оролцоогүй, тухайн хөрөнгө, орлогыг хахууль гэж мэдээгүй хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

-Энэ бүлэгт заасан “төлөөний хүн” гэдэгт хахууль, хууль бус хөрөнгө, орлогыг өгүүлэхээр нийтийн албан тушаалтнаас санал болгосон, зааж өгсөн, тухайн гэмт хэрэгт хамтран оролцсон, эсхүл тухайн хахууль, хөрөнгө, орлогыг хууль бус хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж авсан хүнийг ойлгоно.”

8/22.10 дугаар зүйл:

“22.10 дугаар зүйл.Хууль бусаар хөрөнгөжих

1.Нийтийн албан тушаалтан, түүний төлөөний хүний хөрөнгө, орлого хууль ёсны орлогоос их хэмжээгээр нэмэгдсэн нь хууль бус болох нь тогтоогдсон бол хууль бусаар нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтан, эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгө, орлого нь онц их хэмжээгээр нэмэгдсэн нь тогтоогдсон бол хууль бусаар нэмэгдсэн хөрөнгө, орлогыг хурааж нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.

-Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан “онц их хэмжээ” гэдэгт нэг сая нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “хөрөнгө, орлого” гэж эдийн, эдийн бус хөрөнгө, тэдгээрийг өмчлөх, ашиглах, эзэмших эрх, хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр авсан ажил, бараа, үйлчилгээ, түүний үнэ, түүнээс олсон бүхий л ашиг, орлогыг ойлгоно.

-Хууль бусаар нэмэгдсэн хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бөгөөд хураан авах боломжгүй бол шүүх тухайн хөрөнгө, орлогын үнэтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогоос албадан гаргуулж, хураана. Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хууль бусаар нэмэгдсэн хөрөнгө, орлого болохыг мэдсээр байж авсан бол шүүх тухайн хөрөнгө, орлогыг хураана.

9/22.13 дугаар зүйл:

“22.13 дугаар зүйл.Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах

1.Нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс ажлын чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан, эсхүл бусад этгээд болон төлөөний хүнд хахууль өгүүлсэн, өгүүлэхээр тохиролцсон, өгөхийг

шаардсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдсэн, эсхүл их хэмжээний хахууль авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний хахууль авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хасаж арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлд заасан “их хэмжээ” гэдэгт нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.

-Энэ зүйлд заасан “онц их хэмжээ” гэдэгт нэг сая нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно.”

4 дүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн тайлбар дахь “Засгийн газрын агентлагийн даргыг” гэснийг “Засгийн газрын агентлагийн даргын албан тушаалд ажиллаж байгаа болон сүүлийн 10 жилийн хугацаанд ажиллаж байсан хүнийг” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “дарамт шахалт үзүүлж, давуу байдал бий болгож, бий болгохоор амлаж, ятгаж” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/1.5 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:

“5.Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан үндэслэл байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал нь явуулна.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан тохиолдолд шүүх гэмт хэрэгт холбогдсон хүн, хуулийн этгээдийн гэм буруутай эсэхийг шийдвэрлэхээс гадна гэм буруутай тохиолдолд шийтгэх тогтоол гаргаж, тус тогтоолоор гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгох, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хянан шийдвэрлэнэ.”

2/6.1 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:

“5.Цагдаагийн байгууллага Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт явуулж, яллагдагчаар татах хүртэлх шатанд мөрдөн шалгах ажиллагааг явуулна.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу яллагдагчаар татсанаас хойшхи мөрдөн шалгах ажиллагааг Авлигатай тэмцэх газар явуулна.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтын “яллагдагч” гэсний өмнө “Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд” гэж, 13.3 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “гэмт бүлгийн үйлдсэн” гэсний дараа “, эсхүл авлигын” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Авлигатай тэмцэх газар дараах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:

2.1.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан, нийслэлд гарсан, эсхүл Авлигатай тэмцэх газар өөрсдөө илрүүлсэн бөгөөд нийслэлээс бусад нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэгт;

2.2.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт.”

2/6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Цагдаагийн байгууллага дараах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:

3.1.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэгт;

3.2.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан, нийслэлээс бусад нутаг дэвсгэрт гарсан, эсхүл цагдаагийн байгууллага өөрсдөө илрүүлсэн гэмт хэрэгт;

3.3.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт.”

4 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ